# "МОННАБ" ХК- ний Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны үйл ажиллагааны тайлан

"МОННАБ" ХК- ний Төлөөлөн удирдах зөвлөл нь ердийн 6 гишүүн, хараат бус 3 гишүүн, нийт 9 гишүүнтэй.

1.Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Р.Зоригт,

Ердийн гишүүд : Т.Бадамжунай ,Ш.Оюун -Эрдэнэ, Р.Алтанцэцэг,Л.Мөнхтуяа Д.Пүрэв

Хараат бус гишүүд : Л.Амарсайхан, Г.Төгөлдөр, Д.Болорцэцэг нар ажилласан.

ТУЗ-ийн бүрэлдэхүүн ТУЗ-ийн үйл ажиллагааны төлөвлөгөөг гаргаж 2026 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хүртэл хугацаанд хэрэгжихээр шинэчлэн баталж, хэрэгжилтийг ханган ажилласан. ТУЗ -н хурлыг 5 удаа хуралдуулж хэлэлцэх асуудлуудыг хэлэлцэж, ТУЗ, дэргэдэх хороодын үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгч, компанийн мөрдөж байгаа журмыг хэрэгжүүлэхэд анхаарсан.

2. Хурлын мэдээлэл:

Тайлант хугацаанд Төлөөлөн удирдах зөвлөл 5 удаа, хороод 2 удаа, тус тус хуралдсан. ТУЗ-ийн хурлыг зохион байгуулж , хэрэгжилтийг хангуулж, хяналт тавин ажиллаа. 2025 онд ТУЗ-ийн хурлын ирц хурлын ирц 80-88 хувь байлаа. Хурлыг тасалсан болон чөлөө авсан гишүүн байгаагүй өвчтэй 2 гишүүн байсан.

3.ТУЗ-ийн дэргэдэх хороодын үйл ажиллагаа

Төлөөлөн удирдах зөвлөл нь - Аудитын хороо,
- Нэр дэвшүүлэх хороо,
- Цалин урамшууллын хороотой

-Аудитын хороо

Даргаар хараат бус гишүүн Л.Амарсайхан, гишүүдээр хараат бус гишүүн Г.Төгөлдөр, ердийн гишүүн Р.Алтанцэцэг нар ажиллалаа.

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин урамшуулалын тухай эх үүсвэрийг яаж шийдвэрлэх,компанийн санхүүгийн байдлыг яаж сайжруулах;
2. Компанийн 2026 оны эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалт татах төлөвлөгөөний талаар санал, дүгнэлтээ гарган ТУЗ-ийн хуралд танилцуулсан;
3. Компанийн санхүүгийн тайланд дүгнэлт өгч, санал дүгнэлтээ ТУЗ-ийн хурлаар танилцуулж, хэлэлцүүлсэн;

-Нэр дэвшүүлэх хороо

Даргаар хараат бус гишүүн Г.Төгөлдөр, Д.Болорцэцэг ,гишүүн Д.Пүрэв нар ажиллав. Тайлант хугацаанд Нэр дэвшүүлэх хороо дараах үйл ажиллагааг явууллаа.

1. ТУЗ -н жилийн ажлын үнэлж дүгнэн хуралд танилцуулсан
2. Гүйцэтгэх захирлын гэрээний биелэлтийг дүгнэх гэрээний хавсралтын дагуу үнэлж, санал дүгнэлтээ ТУЗ-ийн хурлаар танилцуулсан.
3. Төлөөлөн удирдах зөвлөл Гүйцэтгэх захиралтай байгуулах хөдөлмөрийн гэрээний нөхцөл, Гүйцэтгэх захирлын ажлыг дүгнэх шалгуур үзүүлэлтийн тухай санал дүгнэлтээ ТУЗ-ийн хурлаар танилцуулж, Гүйцэтгэх захирлын 2025 оны гэрээг шинэчлэн батлуулсан байна.

- Цалин, урамшууллын хороо

Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Цалин, урамшууллын хорооны даргаар хараат бус гишүүн Д.Болорцэцэг, Л.Амарсайхан гишүүдээр ердийн гишүүн Л.Мөнхтуяа нар тус тус ажиллаж, хороо дараах үйл ажиллагааг явууллаа.

1. Хороо нь эрх бүхий албан тушаалтны цалин, урамшууллын талаар ТУЗ-аар хэлэлцүүлж хэрэгжилтэд нь хяналт тавих, холбогдох хууль, дүрэм, журамд нийцүүлэн санал гаргасан.

урамшууллын бодлого, эрх зүйн акт нь бизнес төлөвлөгөө, ажилтны ажлын үр дүнтэй уялдаж байгаа талаарх дүгнэлтээ бусад хороод болон ТУЗ -р хэлэлцүүлсэн

3.Компанийн ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшууллын талаар хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх санал оруулсан

" МОНHАБ " ХК -ний
ТУЗ-н дарга, гишүүд, нарийн бичгийн даргын ажлын гүйцэтгэл

2025 он

| Д/д | Овог нэр | Албан тушаал | ТУЗ-н Хуралд оролцсон | ХЭХуралд оролцсон байдал | ТУЗ н аль нэг хороонд ажилласан байдал | Үнэлгээ /тайлбар/ |
|---|---|---|---|---|---|---|
| 1. | Р.Зоригт | ТУЗ н дарга | 5 | 1 | 2 | хангалттай |
| 2. | Т.Бадамжунай | ТУЗ н гишүүн | 2 | 1 | 0 | Бүрэн хангалттай биш /өвчтэй байсан/ |
| 3. | Д.Пүрэв | ТУЗ н гишүүн | 2 | 0 | 1 | Бүрэн хангалттай биш /өвчтэй байсан/ |
| 4. | Ш.Оюун-Эрдэнэ | ТУЗ н гишүүн | 5 | 1 | 2 | хангалттай |
| 5. | Р.Алтанцэцэг | ТУЗ н гишүүн | 5 | 1 | 2 | хангалттай |
| 6. | Д.Болорцэцэг | ТУЗ н хараат бус гишүүн | 5 | 1 | 2 | хангалттай |
| 7. | Г.Төгөлдөр | ТУЗ н хараат бус гишүүн | 5 | 1 | 2 | хангалттай |
| 8. | Л.Мөнхтуяа | ТУЗ н гишүүн | 5 | 1 | 2 | хангалттай |
| 9. | Л.Амарсайхан | ТУЗ н хараат бус гишүүн | 4 | 1 | 2 | хангалттай |
| 10. | З.Жаргал | ТУЗ-н нарийн бичиг | 5 | 1 | 2 | хангалттай |

"МОНHАБ" ХК- ний Төлөөлөн удирдах зөвлөл

2026-01-05

Батлав. ТУЗ-н Дарга........................................Р.Зоригт

2026 онд ТУЗ -н бүрэлдэхүүнийг сургалтанд хамруулах төлөвлөгөө

2026 он

| | Сургалтын нэр | Хийгдэх хугацаа | Хариуцсан байгууллага, ажилтан | Тайлбар |
|---|---|---|---|---|
| 1 | Санхүү, аудит эрсдлийн тухай | 1 р улиралд | Хүний нөөцийн мэргэжилтэн | Аудит Т.Ундармаа 2026-03-30 |
| 2 | Компанийн ТУЗ-н гишүүдэд зориулсан хууль эрх зүйн сургалт | 6 р сард | Хүний нөөцийн мэргэжилтэн | Татварын хуулийн шинэчлэлийн тухай С.Энхжаргал 2026-06-15 |
| 3 | Удирдах ажилтны сургалт | 12 дугаар сард | Хүний нөөцийн мэргэжилтэн | 2026-12 сард хийхээр төлөвлөж байна |
| 4 | Чиглүүлэх сургалт | Тухай бүрд нь | ТУЗ -н нарийн бичиг | ТУЗ-н гишүүд өөрчлөгдөх шинээр томилогдсон гишүүдэд зориулсан |